



МОНГОЛ ТУТМЫН ХЭВЛЭЛ  
06 дугаар сэрхэн 14  
№22 /643/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

730

МОНГОЛ УЛСЫН  
СГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

741

МОНГОЛ УЛСЫН  
ЭЭД ШҮҮХИЙН  
ТОГТООЛ

753

**Энхийг дэмжих ажиллагаанд  
оролцох тухай**

**Хуулийн давхардал, хийдэл,  
зөрчлийг арилгах зарим арга  
хэмжээний тухай**

**Ашигт малтмалын тухай  
хуулийн зарим зүйл, заалтыг  
тайлбарлах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |     |
|------|--|-----|
| 177. | Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай  | 730 |
| 178. | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 736 |
| 179. | Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай   | 737 |
| 180. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 737 |
| 181. | Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 738 |
| 182. | Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 738 |
| 183. | Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 739 |
| 184. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 739 |
| 185. | Хууль хүчингүй болсонд тооцох тухай  | 740 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 186. | Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 66 | 740 |
| 187. | Хуулийн давхардал, хийгдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай                           | Дугаар 68 | 741 |
| 188. | Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай   | Дугаар 72 | 742 |
| 189. | 2010 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай                      | Дугаар 78 | 744 |



190.	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 79	749
191.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 80	749
192.	Үндэсний хороо байгуулах тухай	Дугаар 81	750
193.	Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртгэх талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 84	751

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

194.	Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 09	753
------	--	-----------	-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ

*/Шинэчилсэн найруулга/*

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, онцгой байдлын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд оролцох, түүнд хамаарах сургалт, дадлага, хангалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж

2.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Батлан хамгаалах тухай<sup>2</sup>, Зэвсэгт хүчний

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Батлан хамгаалах тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.



тухай хууль<sup>1</sup>, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Энхийг дэмжих ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэр, хоёр талын болон олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй байна.

### **3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.1.1.“энхийг дэмжих ажиллагаа” гэж олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, зэвсэгт мөргөлдөөнийг таслан зогсоох, түүний хор үршгийг арилгах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бүс нутгийн холбогдох байгууллага, аливаа улсын удирдлага, зохион байгуулалтын дор явагдаж байгаа олон үндэстний үйл ажиллагааг;

3.1.2.“бие бүрэлдэхүүн” гэж энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, онцгой байдлын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг;

3.1.3.“зэвсэгт хүчний цэргийн баг” гэж энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон зохих бүтэц, орон тоо, зэвсэглэл, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлс бүхий бие бүрэлдэхүүнийг;

3.1.4.“сургалт, дадлага” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнд мэдлэг, чадвар олгоход чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

**4 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч**

4.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь

<sup>1</sup> Зэвсэгт хүчний тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 21 дугаарт нийтлэгдсэн.



цэргийн албан хаагч, зэвсэгт хүчний цэргийн баг байна.

4.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгогдож, уг ажиллагааны өмнөх тусгай сургалтад хамрагдсан байна.

#### **5 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүрэг**

5.1.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд дараахь төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр зэвсэгт хүчний цэргийн багийг оролцуулна:

5.1.1.гал зогсоох гэрээний биелэлтэд хяналт тавих;

5.1.2.мөргөлдөгч талуудыг тусгаарлах, зэвсэг хураах;

5.1.3.зэвсэгт мөргөлдөөний хор уршгийг арилгах;

5.1.4.инженерийн болон бүтээн байгуулалтын бусад ажил

гүйцэтгэх;

5.1.5.дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг

үзүүлэх;

5.1.6.эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх;

5.1.7.аюулгүй байдлыг хангах байгууллагын бие

бүрэлдэхүүнийг сургах;

5.1.8.Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бусад

үүрэг.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

#### **6 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх**

6.1.Монгол Улсын Засгийн газар нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Монгол Улсын Үндэстний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн зэвсэгт хүчний цэргийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах;

6.1.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн холбогдох байгууллага, бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах;

6.1.3.бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон санхүүгийн нөөцийг жил бүрийн улсын төсөвт тусган Улсын Их Хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;



6.1.4.бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон нэмэлт санхүүгийн нөөц шаардагдсан тохиолдолд тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх;

6.1.5.энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах, энэ төрлийн арга хэмжээнд зэвсэгт хүчний цэргийн багийг оролцуулах;

6.1.6.Монгол Улсаас хилийн чанадад энхийг дэмжих ажиллагаа, сургалт, дадлагад оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн болон өөрийн оронд зохион байгуулах энэ төрлийн сургалт, дадлагад оролцох гадаад орны бие бүрэлдэхүүн, тэдгээрийн зэвсэглэл, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсэд хил, гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журмыг тогтоох;

6.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийн төрөл, хэмжээг тогтоох;

6.1.8.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журмыг тогтоох;

6.1.9.энхийг дэмжих ажиллагаанд бэлтгэх, оролцох асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийг мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэйгээр шаардлагатай үед байгуулж, ажиллах журмыг тогтоох.

## **7 дугаар зүйл.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

7.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, дадлага, тусламж, дэмжлэгийн асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

7.1.2.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, дадлагад оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, холбогдох улс, бүс нутгийн байгууллагатай харилцаж, зохицуулах;



7.1.3.энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, дадлагад оролцож байгаа бие бүрэлдэхүүний эрхийг хамгаалах;

7.1.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журам зөрчсөн буюу эрүүл мэндийн байдал, ар гэрийн шалтгаанаар үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд энэ хуулийн 8.1.3-т заасны дагуу холбогдох байгууллагын саналыг үндэслэн эгүүлэн татах асуудлыг шийдвэрлүүлэх.

## **8 дугаар зүйл.Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

8.1.Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.зэвсэгт хүчний цэргийн багийг энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, дадлагад оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

8.1.2.цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагын сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаа, сургалт, дадлагад оролцуулах бие бүрэлдэхүүнийг томилох;

8.1.3.энэ хуулийн 7.1.4-т заасан шалтгааны улмаас бие бүрэлдэхүүнийг эгүүлэн татах;

8.1.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

8.1.5.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа байдлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэх;

8.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд<sup>4</sup> заасны дагуу зарцуулах;

8.1.7.цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагын санал болгосноор энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие

<sup>4</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **9 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал**

9.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал нь уг ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн байгууллага, тухайн ажиллагаа явагдаж байгаа улстай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.

9.2.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн тухайн ажиллагааг удирдахаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бус нутгийн байгууллага, аливаа улсын шийдвэрээр байгуулагдсан олон үндэстний цэргийн хүчний командлагд захирагдах бөгөөд энэ нь бие бүрэлдэхүүн энхийг дэмжих тухайн ажиллагааны бүсэд байх хугацаанд хамаарна.

9.3.Бие бүрэлдэхүүн нь Монгол Улсын зэвсэгт хүчний дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдэгтэй байх бөгөөд тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрээр тусгай таних тэмдэг нэмж хэрэглэж болно.

9.4.Бие бүрэлдэхүүн энхийг дэмжих ажиллагаанд оролцохдоо эрх зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

#### **10 дугаар зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал**

10.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал нь сургалт, бэлтгэл, хангалт, оролцох үеийн зардлаас бүрдэх бөгөөд уг зардлыг жил бүрийн улсын төсвийн батлан хамгаалах арга хэмжээний зардалд тусгасан байна.

10.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүний цалин хангамж, эдийн засгийн бусад баталгааг төр хариуцна.

10.3.Бие бүрэлдэхүүний урьд эрхэлж байсан албан тушаалыг





хэвээр хадгалж, өөрөө зөвшөөрсөн тохиолдолд цалин, нэмэгдлийг итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.

10.4. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд заавал хамруулсан байх бөгөөд даатгалтай холбогдон гарах зардлыг тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллага, аливаа улстай байгуулсан хоёр талын болон олон талт олон улсын гэрээнд тусгаагүй бол Засгийн газрын тусгай сангийн хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

10.5. Энхийг дэмжих ажиллагаанд зэвсэгт хүчний цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.

10.6. Бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж яваад амь эрсэдсэн, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд<sup>5</sup> заасны дагуу шийдвэрлэнэ.

### **11 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

11.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д. ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "энхийг сахиулах" гэснийг "энхийг дэмжих" гэж өөрчилсүгэй.

<sup>5</sup> Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтын "энхийг сахиулах олон улсын хамтын" гэснийг "энхийг дэмжих" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Зэвсэгт хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25<sup>1</sup> дүгээр зүйлийн 25<sup>1.1</sup>.1 дэх заалтын "Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны" гэснийг "энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны" гэж, мөн зүйлийн 25<sup>1.2</sup>, 25<sup>1.5</sup>, 25<sup>2.1</sup> дэх заалтын "Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад" гэснийг, 25<sup>2.4</sup> дэх заалтын "олон улсын цэргийн" гэснийг, 25<sup>2.5</sup> дахь заалтын "олон улсын энхийг сахиулах болон олон улсын бусад" гэснийг тус тус "энхийг дэмжих" гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д. ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож байгаа энхийг сахиулагч" гэснийг "энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа цэргийн албан хаагч" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д. ДЭМБЭРЭЛ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын "цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг" гэснийг "цэргийн анги, салбарын асуудлыг" гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн "Энхийг сахиулах болон олон улсын" гэснийг "Энхийг дэмжих" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8 дахь заалтын "энхийг сахиулах болон олон улсын бусад" гэснийг "энхийг дэмжих" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д. ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар  
хот

### Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.1, 5.13, 5.14, 5.15-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Боловсролын хүрээлэнгийн бүтцэд казах хүүхдийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиг үүрэг бүхий сектор байгуулж, бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Э.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт нарт тус тус даалгасугай.

2. Казах хэл дээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, казах болон монгол хэл судлах цагийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох замаар сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Э.Отгонбаярт үүрэг болгосугай.

3. Аймгийн боловсролын байгууллагын удирдлага, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, казах иргэдийн монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Баян-Өлгий аймгийн Засаг дарга С.Хавалд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж явц байдлын талаар 2010 оны 9 дүгээр сард, хүрсэн үр дүнгийн талаар 2011 оны 10 дугаар сард тус тус Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Ё.ОТГОНБАЯР**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 3 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

**Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг  
арилгах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ НЬ:**

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

а) эрхэлсэн салбарын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн төлөв байдалд судалгаа хийж, тэдгээрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах;

б) хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Төрийн нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаалтнаар ахлуулан иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо бүхий ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

в) яамныхаа бүтэц, орон тоонд багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн нэгж байгуулах арга хэмжээ авах;



г) хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажилд шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж, жил бүрийн төсөвтөө тусгаж байх.

2. Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, "Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал"-ыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, уг аргачлалыг мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажилд шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж, олон улсын зээл, тусламж, төсөл арга хэмжээнд хамруулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явцад хяналт тавьж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах ажлын дүнг хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 3 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот

### **Тооны дээд хязгаар, мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5, 8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. 2010 онд цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг 2010 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 2.300.000 /хоёр сая гурван зуун мянган/ төгрөг байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Л.Болд, Сангийн сайд С.Баярцогт нарт, цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД**

**Л.БОЛД**

Засгийн газрын 2010 оны 72 дугаар  
тогтоолын хавсралт

**2010 ОНД ЦЭРГИЙН АЛБЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХААХ  
ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР**

№	Аймаг, нийслэл	Тооны дээд хязгаар
1	Архангай	80
2	Баян-Өлгий	30
3	Баянхонгор	60
4	Булган	35
5	Говь-Алтай	50
6	Говьсүмбэр	10
7	Дархан-Уул	30
8	Дорноговь	36
9	Дорнод	60
10	Дундговь	50
11	Завхан	30
12	Орхон	30
13	Өвөрхангай	55
14	Өмнөговь	40
15	Төв	60
16	Увс	60





17	Сүхбаатар	40
18	Сэлэнгэ	40
19	Ховд	80
20	Хөвсгөл	80
21	Хэнтий	30
22	Улаанбаатар	78
	Бүгд	1064

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 78

Улаанбаатар  
хот

### 2010 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2010 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хэвсрэлт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэвсрэлтэд заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, дотоодын төрийн бус байгууллага болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны зөвшөөрөл бүхий гадаадын төрийн бус байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хүртэл хувь байхаар тус тус баталсугай.

3. Энэ тогтоолын хэвсрэлтэд заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Т.ГАНДИ**

**БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН 2010 ОНД ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ,  
МЭРГЭЖИЛТНИЙ НИИТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ**

Сансар	Дэд сансар	Бүжэг	Анг	Тодорхойлолт	Дүрийн сан, хөрөнгө оруулалтын хэмжээ (сая төг)																
					50 хүртэл		51-100		101-500		501-ээс дээш		501-ээс дээш								
					100 хүртэл	101-500	100 хүртэл	101-500	100 хүртэл	101-500	100 хүртэл	101-500	100 хүртэл	101-500							
A				ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС БАРИЛТ, АН АГНУУР	8	9	10	9	10	11	10	11	12	11	12	11	12	13	501-ээс дээш	101-500	
B	01			Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд туслах үйл ажиллагаа																	
	06			УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	60	70	75	75	75	75	75	75	75	75	75	75	75	75	75	75	
	09	066	0990	Түүхий газрын тос, байгалийн хийн кайгуул, олборлолт Уул уурхайн кайгуул, олборлолтын бусад туслах үйл ажиллагаа	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	
C				БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ																	
	10			Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	5	6	7	6	7	6	7	6	7	6	7	6	7	6	9	8	10



13		Нэхмэлийн үйлдвэрлэл	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40		
20		Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8	9	10	9	10	11	10	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	11	12	13
23		Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5	10	15	10	15	20	15	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	20	25	30
24		Металл үйлдвэрлэл	5	5	5	10	10	10	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15	15
32		Бусад боловсруулах үйлдвэрлэл	8	9	10	9	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11	10	11
D		ЦАХИЛГААН ХИЙ, УУР АГААРЖУУЛАЛТЫН ХАНГАМЖ	5	6	7	6	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	9	
E		УСАН ХАНГАМЖ, БОХИР УС, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭЖ ҮЙЛ АЖИЛЛАГАА	5	6	7	6	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	9	
F		БАРИЛГА	15	20	25	20	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30	25	30
41	410 4100	Барилга угсралт	20	25	30	25	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35
		Уул уурхайн барилга угсралт, бусад	20	25	30	25	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35
	421 4210	Төмөр зам болон автозамын байгууламж барих үйл ажиллагаа	20	25	30	25	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35	30	35
G		БӨӨНИЙ БОЛОН ЖАХИЛГАН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ																																						
45		Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	5	6	7	6	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	7	8	9	



Н					5	6	7	8	9	10
I			ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА							
	55		Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа		5	5	10	10	15	20
	56		Хоол ундаар үйлчлэх үйл ажиллагаа		5	5	10	10	15	20
M			МЭРГЭЖЛИЙН, ШИЖЭЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА							
	72		Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа		30	30	30	30	30	30
N			ЗАХИРГААНЫ БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА							
		791	Автал, жуулчлалын агентлаг, автлын операторын үйл ажиллагаа		10	15	20	25	30	35
P			БОЛОВСРОЛ							
		851,852,854	Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа		40	40	40	40	40	40
		853	Техник, мэргэжлийн дунд, боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа		30	30	30	30	30	30
Q			ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА							



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2010 оны 3 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 79

Улаанбаатар  
хот**Журамд өөрчлөлт оруулах тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-ын 11 дэх заалтын "Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга байгууламж барих" гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД****Т.ГАНДИ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2010 оны 3 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот**Тогтоолын хавсралтад нэмэлт  
оруулах тухай**

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

"Жагсаалт, дүрэм батлах тухай" Засгийн газрын 2006 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлоход улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх хилийн боомтын жагсаалт"-ын 1 дэх хэсгийн "-Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт" гэсний дараа "-Өмнөговь аймгийн Гашуунсүхайтын боомт" гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД****Д.ЗОРИГТ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 3 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 81

Улаанбаатар  
хот

### Үндэсний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Утаагүй Улаанбаатар" хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн батлуулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд

Дэд дарга: -Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх;

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр.

Гишүүд: -Сангийн сайд С.Баярцогт;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга;

-Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт;

-Эрүүл мэндийн дэд сайд Ж.Цолмон;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд Д.Нямхүү;

-Ерөнхий сайдын зөвлөх Б.Төмөрхуяг;

-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

Д.Цогтбаатар;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Г.Баясгалан;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн

бичгийн дарга Т.Гантулга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн

бичгийн дарга Б.Мишигжав;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очир;

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатар;

-Татварын ерөнхий газрын дарга Ц.Оюунбаатар;

-Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав;

-Ойн газрын дарга М.Тунгалаг;

-Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин;

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатар;

-Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын дарга Н.Бямбасүрэн;

-Авто замын газрын дарга Б.Энхтөр;

-Эрчим хүчний газрын дарга Ц.Баярбаатар;

-Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Д.Мандах;

-Стандартчилал, хэмжил зүйн газрын дэд дарга Г.Энхтайван;

-Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Баатарзориг;

-Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Ганболд;

-Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа;



- Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Ч.Бат;
- Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга Б.Монхoo;
- Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал С.Баярбаатар;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин;
- Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжав

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр  
сарын 2-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар  
хот

### **Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар авах арга хэмжээний тухай**

Стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. 2010-2012 онд Монгол Улсын иргэн бүрт 1.5 сая төгрөгийг тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны төлбөрийн эрх болон бэлэн мөнгө гэсэн хэлбэрээр олгохоор тогтсугай.

2. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасугай:

2.1. Тэтгэврийн даатгалд хамрагдаагүй иргэдийн судалгааг гаргаж, шимтгэлийг тэтгэврийн санд нөхөн төлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх, шаардагдах хөрөнгийн тооцоог гарган саналаа 2010 оны 6 дугаар сарын 1-ний дотор багтаан Засгийн газарт оруулж, улмаар уг арга хэмжээг 2011 оноос эхлэн хэрэгжүүлэхийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид;





2.2. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийн судалгааг гаргаж, шимтгэлийг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийн тооцоог гарган саналаа 2010 оны 6 дугаар сард багтаан Засгийн газарт оруулж, улмаар уг арга хэмжээг 2011 оноос эхлэн хэрэгжүүлэхийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа нарт;

2.3. Иргэн бүрт дунджаар 500.000 (таван зуун) мянган төгрөгийн хишиг, хувийг бэлнээр олгох арга хэмжээг 2010-2012 онд үе шаттайгаар зохион байгуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд С.Баярцогт нарт.

3. Хүний хөгжил сангаас тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны төлбөрийн эрх, бэлэн мөнгө олгох болсонтой холбогдуулан энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2012 оны төсвийн төсөөлөлд тусгаж, төлбөрийн эрхийг олгох журам, санхүүжүүлэх зарчмын талаар санал боловсруулан 2010 оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт оруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд С.Баярцогт болон холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

4. Төрөөс боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдуулан их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сургуулийн дүрэмт хувцасны төлбөр, ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд хурдавчилсан сургалтаар мэргэжил эзэмшүүлэхэд зориулан төлбөрийн эрх олгох ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

5. Иргэдийг халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор шинээр нэвтрүүлсэн вакцин, нэрийн мэргэжлийн болон явуулын амбулаторийн үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдах төлбөрийн эрх олгох, үүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад даалгасугай.

6. Орон сууц худалдан авах урьдчилгаа, зээл болон зээлийн хүүг төлөхөд зориулан орон сууцны төлбөрийн эрх олгох арга хэмжээг иргэдээ орон сууцжуулах талаар хэрэгжүүлж байгаа Засгийн газрын хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.



7. Иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулахыг Засгийн газрын гишүүдэд, дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор иргэдээс санал авах ажлыг 2010 оны 4 дүгээр сарын 15-наас эхлэн улсын хэмжээнд зохион байгуулж, хишиг, хувь хүртээх хэлбэр бүрээр шаардагдах хөрөнгийн тооцоог гарган 2010 оны 7 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Т.ГАНДИ**

## **МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ**

2010 оны 04 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар  
хот

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Ашигт малтмалын тухай хуулийн /цаашид хуулийн гэх/ зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага



болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасан "... нэг хуулийн этгээдийн нэр дээр олгоно" гэдгийг байршлын хувьд нэг, тодорхой солбилцол бүхий талбайд хамтран ажиллах гэрээ бүхий хэд хэдэн хуулийн этгээд хамтран, эсхүл хуулийн этгээдүүдийн нэгдэл /толгой болон охин компани, консорциум гэх мэт/ зэрэг нь тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага хүсэлт гаргасан этгээдүүдийн аль нэгийг нь нэрээр тусгай зөвшөөрөл өгөхийг ойлгоно.

Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг аль хуулийн этгээдийн нэр дээр олгох асуудлыг тэдгээрийн хамтран гаргасан бичгийн хүсэлт болон гэрээг үндэслэн шийдвэрлэх бөгөөд тусгай зөвшөөрлийг ижил буюу өөр дугаараар давхардуулж олгохгүй.

2. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан "...үргэлжлүүлэн эзэмших давуу эрх..." гэж тухайн талбайд урд нь тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаас өөр болзол, шаардлагагүйгээр тусгай зөвшөөрлийг шууд авах боломжийг хэлнэ.

3. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8-д заасан "... тэргүүн ээлжинд авах давуу эрх ..." гэдгийг урд нь тухайн талбайд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн бүртгэлийн дараалал харгалзахгүйгээр тусгай зөвшөөрлийг эхлэн авах бололцоо гэж ойлгоно.

4. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 14 дүгээр зүйлийн 14.8-д заасан "... урьд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан ..." гэдэгт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг эрх бүхий байгууллагаас бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөөцөд буюу тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах үед уг талбайд хайгуулын ба ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон этгээд хамаарна.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан хугацаанд тусгай зөвшөөрөлөө шинэчлэн бүртгүүлээгүй, хуульд заасан шаардлага хангасан этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлээгүй нь тэдгээрийг цуцлагдсанд тооцогдох үндэслэл болох тул урьд нь тусгай зөвшөөрөлтэй байсан этгээд хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 14 дүгээр зүйлийн 14.8-д заасан "давуу эрх"-ийг эдлэхгүй.

Тусгай хэрэгцээнд байлгах хугацаа дууссан, чөлөөлсөн тухай шийдвэрийг хүлээж авсан төрийн захиргааны байгууллага уг талбайн талаарх тодорхой мэдээллийг өдөр тутмын сониноор нийтэд мэдээлнээс



хойш 1 сарын дотор тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд хүсэлт гаргаагүй бол уг талбайд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг ердийн журмаар шийдвэрлэнэ.

5. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.2.3, 19.2.4, 19.3, 19.7, 20 дугаар зүйлийн 20.2, 22 дугаар зүйлийн 22.4, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4, 26.4-т заасан **"бичгээр мэдэгдэх"** гэж төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүний утгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.

6. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, 26 дугаар зүйлийн 26.3, 28 дугаар зүйлийн 28.2, 30 дугаар зүйлийн 30.2, 39 дүгээр зүйлийн 39.5, 51 дүгээр зүйлийн 51.7, 51.8, 56 дугаар зүйлийн 56.2, 56.4, 62 дугаар зүйлийн 62.6-д заасан **"мэдэгдэнэ"** гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг утгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.

7. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10, 22 дугаар зүйлийн 22.3, 26 дугаар зүйлийн 26.7, 28 дугаар зүйлийн 28.3, 49 дүгээр зүйлийн 49.11, 50 дугаар зүйлийн 50.6, 54 дүгээр зүйлийн 54.5, 55 дугаар зүйлийн 55.6, 56 дугаар зүйлийн 56.7-д заасан нийтлэх ажиллагааг зөвхөн өдөр тутмын сониноор дамжуулан гүйцэтгэнэ.

8. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, 26 дугаар зүйлийн 26.1.1-д заасан **"тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх"** гэдгийг холбогдох баримтыг хүсэлт гаргасан этгээдэд гардуулах буюу хүргүүлснийг хэлнэ.

9. Мөн зүйлийн 19.4-т заасан **"хурлын санал"** нь төрийн захиргааны байгууллагын мэдэгдэлд заасан тухайн талбайд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн сум, дүүрэг болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоол байна.

Энэ зүйл, хэсэгт заасан **"... хариу ..."**-г аймаг, нийслэлийн Засаг дарга зөвхөн бичгийн хэлбэрээр өгнө.

10. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д заасан **"...татгалзсан хариу өгч болно"** гэдгийг энэ хууль болон бусад хуулиар ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглосон, хязгаарласан, түүнчлэн эрх бүхий байгууллагаас тухайн талбайг холбогдох хуулийн дагуу нөөцөд болон



тусгай хэрэгцээнд авсан зэргийг үндэслэл болгож, тусгай зөвшөөрөл олгох боломжгүй тухай шийдвэрийг мэдэгдэл ирүүлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхийг ойлгоно.

11. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан "... ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрх ..." нь хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу ашиглалтын өмнөх гэрээ байгуулсан этгээдэд нэгэн адил хамаарах бөгөөд уг этгээд нь тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргахдаа хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан шаардлагуудыг хангасан байвал зохино.

12. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанаас хойш тусгай зөвшөөрлийн эхний жил дуусгавар болох өдөр хүртэлх хугацааны дотор төлснийг дараа жилийн төлбөрийг урьдчилан төлсөн гэж үзнэ.

13. Хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан "... нутгийн захиргааны байгууллага..."-д тусгай зөвшөөрөл бүхий тухайн талбай байрших сум, дүүрэг, аймаг нийслэлийн засаг дарга, түүний тамгын газар хамаарна.

14. Хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасан "нутгийн захиргааны байгууллага" гэдэгт тусгай зөвшөөрөл бүхий тухайн талбай байрших сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүнчлэн хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэгч байгаль орчны болон мэргэжлийн хяналтын алба зэргийг хамааруулан үзнэ.

15. Хуулийн холбогдох зүйл, хэсэгт заасан тодорхой хугацаануудыг Иргэний хуулийн 8 дугаар бүлэгт заасан журмыг баримтлан тоолж, тодорхойлно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**

**С.БАТДЭЛГЭР**

**ШҮҮГЧИД**

**Д.ПУНЦАГ  
П.ЦЭЦГЭЭ**

**Хаяг:**

"Төрийн мэдээлэл" эхсэтгэлийн редактор


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1.75

Нислэц: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэл хэргийн хэлтэс хэвлэв.  
Утас 329487